



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн талаар

Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн
хэлтсийн ахлах референт Д.Лхагвасүрэн



Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль

УИХ-аас 2021.12.17-ны өдөр Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг баталсан бөгөөд 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд 13-т “...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” мөн зүйлийн 17-д “...хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;” гэж тус тус заасны дагуу хувь хүний нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах үндэслэл бий болсон бөгөөд УИХ 1995 онд Хувь хүний нууцын тухай хуулийг анх баталсан байдаг.



Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль

4.1.8."мэдээлэл хариуцагч" гэж хуульд заасны дагуу, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг;

4.1.11-т "хүний хувийн мэдээлэл" гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг;

4.1.12."хүний эмзэг мэдээлэл" гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг;



Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуультай холбоотойгоор анхаарах асуудал

Хүний хувийн мэдээллийг боловсруулах, цуглуулах, ашиглахдаа мэдээллийн эзнээс бичгээр (цаасан, эсхүл цахим хэлбэрээр) зөвшөөрөл авсан байх

Мэдээллийн эзэн болон мэдээллийг хуульд заасны дагуу, эсхүл иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах бичиг баримтаар таньж, баталгаажуулах

мэдээллийн эзэн мэдээлэл цуглуулахад зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд үүсэж болох үр дагаврыг тайлбарлах

Мэдээллийн эзний хүсэлтийн дагуу мэдээллийг засах, өөрчлөх, устгах, энэ талаар мэдээллийн эзэнд мэдэгдэх

Мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд шийдвэр гаргах, түүнээс гарах үр дагаврын талаар мэдээллийн эзэнд тайлбарлах

Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах дотоод журам баталж, мөрдүүлэх

Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотой гомдол гаргах эрхийн талаар мэдээллийн эзэнд тайлбарлах, гомдлыг хүлээн авч шийдвэрлэж, хариу мэдэгдэх

Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны талаар бүртгэл хөтлөх, үйл ажиллагааны явцад олж авсан мэдээллийг хадгалах

Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны талаар бүртгэл хөтлөх, үйл ажиллагааны явцад олж авсан мэдээллийг хадгалах

Улсын бүртгэлийн ерөнхий хууль

5 дугаар зүйлийн 5.11-т “Иргэний бүртгэлийн дугаарт үндэслэн суурь болон төрөлжсөн мэдээллийн сан үүсгэж, төрийн үйлчилгээг үзүүлнэ”

6 дугаар зүйлийн 6.2-т “Монгол Улсын иргэний үнэмлэх нь Монгол Улсын иргэнийг гэрчлэх бичиг баримт байх бөгөөд түүнийг авах хүртэл 16-аас доош насны иргэний хувьд иргэний бүртгэлийн дугаартай төрсний гэрчилгээ байна.”

Регистрийн дугаарын 2 үсэг нь тухайн хүнийг хаана төрснийг мэдээлдэг.

- Эхний үсэг нь төрсөн буюу регистрийн дугаар олгосон аймаг, дүүргийн код.
- Дараагийн үсэг нь сум, хорооны код.
- Тооны эхний 6 орон нь төрсөн он, сар, өдөр байна.
- 7 дахь тоо нь тухайн хүний хүйсийг илтгэнэ.
- 8 дахь тоо нь хяналтын код юм. Хяналтын код нь регистрийн дугаарын үсэг, тоонуудыг өөрчлөх, алдахаас хамгаална.
- Регистрийн дугаар бол хүн бүрийг таних, дахин давтагдашгүй код юм.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль зөрчвөл

Зөрчлийн тухай хууль

6.27 дугаар зүйл. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчих

1. Мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авсан зорилгоос өөр зорилгоор хүний хувийн мэдээллийг ашигласан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг зөрчиж, хууль зүйн сөрөг үр дагавар үүсгэж болох шийдвэр гаргах нөхцөл бүрдүүлсэн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Хүний эмзэг мэдээллийг хууль бусаар олж авсан, боловсруулсан, бусдад дамжуулсан, задруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Эрүүгийн хууль

13.8 дугаар зүйл. Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах
1. Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд, эсхүл гадна талаас орон байрны доторх орчны болон орох, гарах хэсгийг хамруулан гэрэл зураг авч, эсхүл дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, эсхүл бусдад дамжуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хийсэн гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж орон байранд, гадна талаас орон байрны доторх орчны болон орох, гарах хэсгийг хамруулан гэрэл зураг авсан, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

4. Хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, бусдад дамжуулсан, эсхүл эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг олон нийтэд тараасан нь мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн шинжгүй бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА